

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/27-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг:naranchimegts@gaudit.gov.mn Аудитын менежер:С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг:natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор:Э.Бат-эрдэнэ Утас: 261885 Цахим хаяг:baterdenee@audit.gov.mn Пийк ОМ Аудит ХХК-ийн захирал:Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomauditllc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Төлбөрийн акт	23
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/429
танай _____-ны № _____-т

БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.АМАРЗАЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилгын политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 269,887.1 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд багшийн бичиг хэргийн материал, сургуулийн хэвлэмэл танилцуулгын төлбөр гэсэн утгатай нийт 7,950.0 мянган төгрөг шилжүүлж, бодитоор бэлэг дурсгалын зориулалттай 2 нэр төрлийн 109 ном худалдан авсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж 19,531.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- Тус сургуульд 2021 онд хөрөнгө оруулалтаар "Интер сайнс" ХХК-иас нийлүүлэгдэн анх ирэхдээ үйлдлийн систем гэмтэлтэйн улмаас ашиглах боломжгүй 3 нэр төрлийн симулятор гэх сургалтын зориулалттай төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэлд 205,537.0 мянган төгрөгөөр тусгасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.4,

15.1.8 дах заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус коллежийн гагнуурчин, барилгын цахилгаанчин, иргэний барилгын техникч, бетон арматурчин мэргэжлийн хөтөлбөрүүд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх комиссын тогтоолоор тус тус 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус коллежийн 1963 онд ашиглалтад орсон, санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1,043,324.2 мянган төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, оюутны дотуур байрны зориулалттай 4 давхар барилга нь ашиглалтын хугацаа дууссан, инженерийн шугам сүлжээний доголдолтой зэргээс шалтгаалан чанарын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй болсон байна.

Бусад асуудал

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	867,992,736.73	757,356,512.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	188,962,921.34	158,484,880.24
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	188,962,921.34	158,484,880.24
31210	Төгрөг	188,962,921.34	158,484,880.24
31211	Төрийн сангийн харилцах	188,562,921.34	158,484,880.24
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	400,000.00	-
33	АВЛАГА	9,874,422.84	1,116,250.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	119,772.84	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	9,754,650.00	1,116,250.00
34	УРЬДЧИЛГАА	86,639,971.13	30,373,584.05
34600	Урьдчилж гарсан зардал	86,639,971.13	30,373,584.05
35	БАРАА МАТЕРИАЛ	582,515,421.42	567,381,798.57
35100	Түүхий эд материал	36,662,955.84	29,962,378.59
35110	Тусгай зориулалттай материал	31,725,117.90	26,113,728.49
35130	Эм боох материал	4,937,837.94	3,848,650.10
35300	Бэлэн бүтээгдэхүүн	9,000.00	-
35400	Хангамжийн материал	545,843,465.58	537,419,419.98
35410	Бичиг хэргийн материал	19,093,770.87	15,162,084.91
35420	Аж ахуйн материал	34,730,427.80	25,619,105.79
35430	Сэлбэг хэрэгсэл	3,345,400.00	3,446,300.00
35440	Түлш, шатах тослох материал	3,643,019.35	-
35450	Барилгын засварын материал	70,440,976.36	54,245,736.36
35470	Бусад хангамжийн материал	414,589,871.20	438,946,192.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,717,262,074.13	5,798,244,749.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,717,262,074.13	5,798,244,749.76
39200	Биет хөрөнгө	5,324,215,512.09	5,406,891,520.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,578,866,513.09	9,569,201,809.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,785,522,069.09)	(5,958,999,171.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,080,000.00	19,290,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,272,500.00)	(19,290,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,354,937,756.15	2,308,585,889.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,277,234,827.82)	(1,040,718,253.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	345,624,291.45	370,923,017.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(173,736,519.42)	(118,458,218.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,056,363.64	24,638,941.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,302,060.78)	(6,064,998.12)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	13,522,650.00	8,113,590.00
39217	Ном	245,195,914.87	249,668,914.87
39300	Биет бус хөрөнгө	393,046,562.04	638,889.06
39301	Программ хангамж	18,760,916.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(18,760,916.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	398,064,340.00	6,300,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(5,017,777.96)	(5,661,110.94)
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	390,714,340.00
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад	-	390,714,340.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	6,585,254,810.86	6,555,601,262.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	92,219,432.61	64,081,707.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	92,219,432.61	64,081,707.27
41300	Өглөг	5,058,402.61	228,727.27

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,438,012.78	8,727.27
41360	Бусад өглөг	620,389.83	220,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	220,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	620,389.83	-
41400	Урьдчилж орсон орлого	87,161,030.00	63,852,980.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	87,161,030.00	63,852,980.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,493,035,378.25	6,491,519,555.35
51	Засгийн газрын хувь оролцоо	6,493,035,378.25	6,491,519,555.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,022,413,154.28	4,022,413,154.28
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	4,022,413,154.28	4,022,413,154.28
51200	Хуримтлагдсан үр дүн	1,893,930,573.43	1,909,584,647.86
51210	Өмнөх үеийн үр дүн	1,157,281,915.55	1,911,100,470.76
51220	Тайлант үеийн үр дүн	736,648,657.88	(1,515,822.90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	576,691,650.54	559,521,753.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	6,585,254,810.86	6,555,601,262.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,426,507,330.27	6,828,133,495.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	235,160,630.27	6,828,133,495.70
120	Нийтлэг татварын бус орлого	235,160,630.27	258,569,690.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	235,160,630.27	258,569,690.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	235,160,630.27	205,019,557.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	53,550,133.00
122	Тусламжийн орлого	-	6,569,563,805.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,569,563,805.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,569,563,805.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,569,563,805.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,191,346,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,190,946,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,190,946,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	400,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,149,522,863.93	6,587,890,546.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,149,522,863.93	6,587,890,546.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,660,325,728.48	6,157,523,566.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,924,491,400.19	4,460,465,796.57
210101	Үндсэн цалин	2,295,532,392.41	2,344,700,327.91
210102	Нэмэгдэл	1,189,865,460.17	1,581,818,102.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	219,176,672.67	289,291,445.43
210104	Урамшуулал	219,916,874.94	244,655,921.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	488,368,219.06	549,627,625.01
210201	Тэтгэврийн даатгалын зардал	333,386,227.76	375,180,572.06
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	38,995,618.09	44,307,758.44
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	19,565,066.01	22,617,425.42
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	19,393,073.10	21,430,982.26
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	77,028,234.10	86,090,886.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,854,132.66	184,652,647.97
210301	Гэрэл, цахилгаан	68,317,878.31	79,192,583.50
210302	Түлш, халаалт	83,089,163.35	77,843,578.59
210303	Цэвэр, бохир ус	26,447,091.00	27,616,485.88
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,937,490.00
210401	Бичиг хэрэг	-	4,937,490.00
2105	Нормативт зардал	140,717,500.00	208,996,200.00
210502	Хоол, хүнс	140,717,500.00	208,996,200.00

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	151,713,800.00	98,665,167.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	22,814,200.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,993,450.00	36,564,967.00
210604	Урсгал засвар	114,670,350.00	39,286,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,900,000.00	136,217,688.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,900,000.00	136,217,688.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	708,280,676.57	513,960,951.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	361,366,680.57	181,631,887.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	346,913,996.00	332,329,064.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	489,197,135.45	430,366,980.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	489,197,135.45	429,966,980.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,240,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	71,319,135.45	153,307,180.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	401,818,000.00	199,022,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,820,000.00	77,637,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	276,984,466.34	240,242,948.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	88,021,545.00	270,720,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,021,545.00	270,720,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	88,021,545.00	270,720,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	88,021,545.00	270,720,990.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(88,021,545.00)	(270,720,990.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	188,962,921.34	(30,478,041.10)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	188,962,921.34
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	188,962,921.34	158,484,880.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,426,507,330.27	6,828,133,495.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	235,160,630.27	6,828,133,495.70
120	Нийтлэг татварын бус орлого	235,160,630.27	258,569,690.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	235,160,630.27	258,569,690.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	235,160,630.27	205,019,557.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	53,550,133.00
122	Тусламжийн орлого	-	6,569,563,805.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,569,563,805.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,569,563,805.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,569,563,805.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,191,346,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,190,946,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,190,946,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	400,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,149,522,863.93	6,587,890,546.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,149,522,863.93	6,587,890,546.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,660,325,728.48	6,157,523,566.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,924,491,400.19	4,460,465,796.57
210101	Үндсэн цалин	2,295,532,392.41	2,344,700,327.91
210102	Нэмэгдэл	1,189,865,460.17	1,581,818,102.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	219,176,672.67	289,291,445.43
210104	Урамшуулал	219,916,874.94	244,655,921.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	488,368,219.06	549,627,625.01
210201	Тэтгэврийн даатгалын зардал	333,386,227.76	375,180,572.06
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	38,995,618.09	44,307,758.44
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	19,565,066.01	22,617,425.42
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	19,393,073.10	21,430,982.26
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	77,028,234.10	86,090,886.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,854,132.66	184,652,647.97
210301	Гэрэл, цахилгаан	68,317,878.31	79,192,583.50
210302	Түлш, халаалт	83,089,163.35	77,843,578.59
210303	Цэвэр, бохир ус	26,447,091.00	27,616,485.88
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,937,490.00
210401	Бичиг хэрэг	-	4,937,490.00
2105	Нормативт зардал	140,717,500.00	208,996,200.00
210502	Хоол, хүнс	140,717,500.00	208,996,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	151,713,800.00	98,665,167.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	22,814,200.00

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,993,450.00	36,564,967.00
210604	Урсгал засвар	114,670,350.00	39,286,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,900,000.00	136,217,688.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,900,000.00	136,217,688.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	708,280,676.57	513,960,951.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	361,366,680.57	181,631,887.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	346,913,996.00	332,329,064.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	489,197,135.45	430,366,980.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	489,197,135.45	429,966,980.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,240,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	71,319,135.45	153,307,180.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	401,818,000.00	199,022,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,820,000.00	77,637,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	400,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	400,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	276,984,466.34	240,242,948.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	88,021,545.00	270,720,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,021,545.00	270,720,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	88,021,545.00	270,720,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	88,021,545.00	270,720,990.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(88,021,545.00)	(270,720,990.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	188,962,921.34	(30,478,041.10)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	188,962,921.34
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	188,962,921.34	158,484,880.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,022,413,154.28	1,105,252,511.09	601,154,755.84	5,728,820,421.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	556,127,159.71	556,127,159.71
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,022,413,154.28	1,105,252,511.09	1,157,281,915.55	6,284,947,580.92
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(528,560,860.55)	-	(528,560,860.55)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	736,648,657.88	736,648,657.88
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,022,413,154.28	576,691,650.54	1,893,930,573.43	6,493,035,378.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,169,897.33	17,169,897.33
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,022,413,154.28	576,691,650.54	1,911,100,470.76	6,510,205,275.58
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(17,169,897.33)	-	(17,169,897.33)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,515,822.90)	(1,515,822.90)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,022,413,154.28	559,521,753.21	1,909,584,647.86	6,491,519,555.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,853,107,400.00	6,828,133,495.70	24,973,904.30	99.6
12	Татварын бус орлого	6,853,107,400.00	6,828,133,495.70	24,973,904.30	99.6
120	Нийтлэг татварын бус орлого	239,085,100.00	258,569,690.70	(19,484,590.70)	108.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	210,185,300.00	205,019,557.70	5,165,742.30	97.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	28,899,800.00	53,550,133.00	(24,650,333.00)	185.3
122	Тусламжийн орлого	6,614,022,300.00	6,569,563,805.00	44,458,495.00	99.3
122005	Төсвөөс санхүүжих	6,614,022,300.00	6,569,563,805.00	44,458,495.00	99.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,974,496,900.00	6,858,211,536.80	116,285,363.20	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,974,496,900.00	6,858,211,536.80	116,285,363.20	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,528,732,800.00	6,428,244,556.80	100,488,243.20	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,461,423,500.00	4,460,465,796.57	957,703.43	100.0
210101	Үндсэн цалин	2,532,459,500.00	2,344,700,327.91	187,759,172.09	92.6
210102	Нэмэгдэл	1,727,433,200.00	1,581,818,102.23	145,615,097.77	91.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	201,530,800.00	289,291,445.43	(87,760,645.43)	143.5
210104	Урамшуулал	-	244,655,921.00	(244,655,921.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	554,991,700.00	549,627,625.01	5,364,074.99	99.0
210201	Тэтгэврийн даатгал	374,338,200.00	375,180,572.06	(842,372.06)	100.2
210202	Тэтгэмжийн даатгал	45,163,300.00	44,307,758.44	855,541.56	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,581,700.00	22,617,425.42	(35,725.42)	100.2
210204	Ажилгүйдлийн даатгал	22,581,700.00	21,430,982.26	1,150,717.74	94.9
210205	Эрүүл мэндийн даатгал	90,326,800.00	86,090,886.83	4,235,913.17	95.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,339,500.00	184,652,647.97	18,686,852.03	90.8
210301	Гэрэл, цахилгаан	60,308,800.00	79,192,583.50	(18,883,783.50)	131.3
210302	Түлш, халаалт	116,352,700.00	77,843,578.59	38,509,121.41	66.9
210303	Цэвэр, бохир ус	26,678,000.00	27,616,485.88	(938,485.88)	103.5
2104	Хангамж, бараа материалын зардал	4,950,000.00	4,937,490.00	12,510.00	99.7
210401	Бичиг хэрэг	4,950,000.00	4,937,490.00	12,510.00	99.7
2105	Нормативт зардал	241,766,600.00	208,996,200.00	32,770,400.00	86.4
210502	Хоол, хүнс	241,766,600.00	208,996,200.00	32,770,400.00	86.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	192,794,600.00	192,782,867.00	11,733.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,226,100.00	69,725,100.00	(4,499,000.00)	106.9
210602	Тавилга	34,250,000.00	35,767,800.00	(1,517,800.00)	104.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,568,500.00	36,564,967.00	3,533.00	100.0
210604	Урсгал засвар	56,750,000.00	50,725,000.00	6,025,000.00	89.4

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	290,096,000.00	255,157,318.75	34,938,681.25	88.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	290,096,000.00	255,157,318.75	34,938,681.25	88.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	579,370,900.00	571,624,611.50	7,746,288.50	98.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,319,200.00	191,572,987.50	7,746,212.50	96.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,051,700.00	380,051,624.00	76.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	445,764,100.00	429,966,980.00	15,797,120.00	96.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	445,764,100.00	429,966,980.00	15,797,120.00	96.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	153,531,400.00	153,307,180.00	224,220.00	99.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	214,456,900.00	199,022,000.00	15,434,900.00	92.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77,775,800.00	77,637,800.00	138,000.00	99.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	188,962,921.34		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	188,962,921.34	158,484,880.24		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	146	146	-	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	119	119	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	24	24	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Барилгын политехник коллеж эрхэм зорилгоо “Мэдлэг, чадвар, хандлагаараа олон улсын жишигт нийцсэн, бүтээн байгуулалтын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх” гэж тодорхойлжээ.

Энэ зорилгын хүрээнд мэргэжлийн боловсрол олгох анхан шатны сургалт 10 мэргэжлээр 2.5 жил, техникийн боловсрол олгох сургалт 8 мэргэжлээр, мэргэжил олгох ба түвшин ахиулах сургалт, барилгын 10 мэргэжлээр, хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт, герман хэлний B1 түвшний сертификаттай сургалтыг тус тус олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус коллеж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд тайлант хугацаанд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны 240 дүгээр “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 27-ны А/112 дугаар “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний А/172 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилгын политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус коллеж Боловсролын яамны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч шинээр батлагдсан хууль, журмын өөрчлөлтүүдийг тусгаагүй бодлогын баримт бичигт шинэчлэлт хийгээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Барилгын политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,253.5 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	188,962.9	158,484.9	(30,478.0)
Авлага	9,874.4	1,116.2	(8,758.2)
Урьдчилгаа	86,640.0	30,373.6	(56,266.4)
Бараа материал	582,515.4	567,381.8	(15,133.6)
Үндсэн хөрөнгө	5,717,262.1	5,798,244.7	80,982.7
Нийт хөрөнгө	6,585,254.8	6,555,601.2	(29,653.6)
Өр төлбөр	92,219.4	64,081.7	(28,137.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,493,035.4	6,491,519.5	(1,515.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,585,254.8	6,556,001.2	(29,653.6)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 158,484.9 мянган төгрөг болж 30,478.0 мянган төгрөгөөр буурсан нь тайланд оны үйл ажиллагаанд зарцуулагдсан.

Авлагын дансны үлдэгдэл 1,116.2 мянган төгрөг болж 8,758.2 мянган төгрөгөөр буурсан нь сургалтын төлбөрийн авлагыг барагдуулсантай холбоотой.

Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 30,373.4 мянган төгрөг болж 56,266.4 мянган төгрөгөөр буурсан нь 2024 оны гэрээт ажлуудыг гүйцэтгүүлж, тайлант онд хүлээн авсантай холбоотой.

Бараа материал дансны үлдэгдэл 567,381.8 мянган төгрөг болж 15,133.6 мянган төгрөгөөр буурсан нь олон жил ашиглаж ирсэн БҮТЭЗ-ийг зардлаар хүлээн зөвшөөрч, бичиг хэрэг, аж ахуйн материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 80,982.6 мянган төгрөгөөр өссөн бөгөөд бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Акталж устгасан хөрөнгөнөөс 860.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авсан, 89,701.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 4,824.0 мянган төгрөгийн хөрөнгө бараа материалаас бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 427 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 640,227.9 мянган төгрөгийн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоож 384,136.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 270,721.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан;
- ТӨБЗГ-ын 2025 оны 596 дугаар тогтоолоор 152,687.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 654,767.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон;

Урьдчилж орсон орлого 63,853.0 мянган төгрөг болж 23,308.0 төгрөгөөр буурсан нь орлогыг хүлээн зөвшөөрсөн болон оюутны байрны ашиглах хугацаа дуусаж хүн амьдрах нөхцөлгүй, мөөгөнцөртэй, инженерийн шугам сүлжээ нь маш муу доголдолтой байгаатай холбоотой 2025-2026 оны хичээлийн жилд 4 дүгээр давхрыг ашиглаагүй хааснаас байрны түрээсийн орлого урьдчилж орж ирээгүйгээс шалтгаалсан.

Судалгааны үр дүн: Тус коллежийн программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2024 онд худалдан авч, ашиглаж байгаа 1,771.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ хангамж байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,702,300.3 мянган төгрөг нийт зарлагыг 6,702,300.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас шинээр элсэн суралцах хүүхдийн тоо, байр ашиглалтын зардал, оюутны байрны хүүхдийн хоолны зардал, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 600,207.0 төгрөгөөр бууруулж, 6,102,093.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсролын нэг хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 6,102,093.3 мянган төгрөгийн төсвийг 1,699.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 6,103,792.4 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Энэ нь оюутны дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 5,740.4 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардлаас 13,766.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас 124,080.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 128,151.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжид 15,434.9 мянган төгрөг тус тус нэмснээр 6,614,022.3 мянган төгрөг байна.

Мөн үндсэн үйл ажиллагааны орлого 210,185.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 28,899.8 мянган төгрөг, төсвийн урамшууллаар 510,229.9 мянган төгрөгийн төсвийн зохицуулалт хийснээр нийт 6,853,107.4 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,059,333.9 мянган төгрөг, гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилтээр 510,229.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 258,569.7 мянган төгрөг, нийт 6,828,133.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж орлогын төлөвлөгөө 99.6 хувьтай байна.

Урсгал үйл ажиллагааны зардал 6,858,211.5 мянган төгрөгөөс 30,078.0 мянган төгрөг нь өмнөх оны мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээс зарцуулагдсан ба нэмэлт санхүүжилтийн харилцах дансны 400.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.3 хувь буюу 6,858,221.5 мянган төгрөг байгаа нь байр ашиглалтын зардлаас 18,686.8 мянган төгрөг, оюутны байрны хүүхдийн хоолны зардлаас 32,770.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 34,938.7 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	71804-Тусгай мэргэжлийн боловсрол	6,974,496.9	6,858,211.5	116,285.4	98.3
1	80219-Харуул, хамгаалалтын зардал	75,400.0	74,111.0	1,289.0	98.3
2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	220,839.5	202,152.6	18,686.8	91.5
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	367,988.3	352,329.2	15,659.1	95.7
4	81806-Дотуур байрны үйлчилгээ	241,766.6	208,996.2	32,770.4	86.4
5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	5,188,950.9	5,183,098.3	5,852.6	99.9
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	638,916.1	597,342.9	41,573.2	93.5
7	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчныг сайжруулах	240,635.5	240,181.3	454.2	99.8

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

1. Боловсролын сайдын 2025 оны 1/554 дүгээр "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг үндэслэн захирлын 2025 оны 02 дугаар сарын 18-ны А/08 дугаар тушаалаар ажлын унаа, хоолны тарифыг 9.5 мянган төгрөгөөр тогтоож тайлант хугацаанд 289,291.4 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.
2. Тайланд онд гадаад томилолтын зардалд 43,579.3 мянган төгрөг төлөвлөснөөс Казакстан улсад зохион байгуулагдсан ур чадварын уралдаанд сантехник, барилгын бүтэц, угсралтын мэргэжлийн нийт 3 багш оролцож 20,301.1 мянган төгрөгийн зардал гарсан. Гадаад томилолтын үр дүнд гагнуурын мэргэжлийн багш 1 дүгээр байр, 3 сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.
3. Төрийн худалдан авах ажиллагааны анхан шатны сургалт, үйлчлэгч нарт үйлчилгээний стандарт, чанарын сургалт, "Ажлын байрны зөөлөн ур чадвар сургалт" 132 багш, ажилтан хамрагдаж сургалтын зардалд 10,320.0 мянган төгрөг зарцуулсан.
4. Хэвлэл, мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажил хийгдээгүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус коллеж нь тайланд онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хичээлийн байрны жижүүр, харуул хамгаалалтын зардалд 64,800.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх материалын зардалд 299,769.0 мянган төгрөг, оюутны байрны хүүхдийн хоолны зардалд 148,504.2 мянган төгрөг, ур чадварын уралдаан, сургалтын хэвийн үйл ажиллагааг явуулах тухай бүр гардаг тусгай захиалга 77,851.9 зарцуулахаар нийт 590,925.1 мянган төгрөг баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 33,911.6 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Барилгын политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Барилгын политехник коллеж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 6,564,068.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 65,640.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон болон хязгаарласан бэлэг, уулзалт, спортын тэмцээн, видео бичлэг танилцуулга 4 арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Барилгын политехник коллеж нь тайлант онд шилэн дансны цахим системд байршуулбал зохих мэдээллээс 19,374,032.9 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах..” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох, өмнөх аудитын шийдвэр болон албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд тус байгууллагын захирлын тушаал шийдвэр, удирдах зөвлөлийн хурлын шийдвэр зэрэгт хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар илэрсэн 9,667.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 19,118.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 албан шаардлага, 2,068.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	19,118.8	3	19,118.8	75.0
Зөвлөмж	3	2,068.8	3	2,068.8	100.0
Нийт дүн	7	21,185.6	6	21,185.6	85.7

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй тул тайлант онд буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,980.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 33,980.6 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тайлант онд 1,814.4 мянган төгрөгийн шатахууны зардлыг түлш халаалтын зардлаар ангилал зөрүүлэн тайлагнасан байна.
- Тайлант онд 32,166.2 мянган төгрөгийн барилгын засварын материалыг хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал дансанд ангилал зөрүүлэн бүртгэсэн зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулав.

Аудитаар нийт 269,887.1 мянган төгрөгийн 10 зөрчил² илэрснээс 7,950.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 53,912.6 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 208,024.5 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 269,887.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 65,640.7 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд багшийн бичиг хэргийн материалын төлбөр, сургуулийн хэвлэмэл танилцуулгын төлбөр гэсэн утгатай нийт 7,950.0 мянган төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шилжүүлсэн боловч бодитоор бэлэг дурсгалын зориулалттай 2 нэр төрлийн 109 номыг худалдан авч, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүй олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Тус коллежид 2026 оны 01 дүгээр сард зохион байгуулагдах, 3 мэргэжлийн зөвлөлийн уулзалтын өглөөний цайны зардалд 470.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар албан даалгаврын 1.4.1 "Хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод гадаад албан томилолт, тээвэр шатахуун, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад 4,531.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.6. Үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8. Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.Илрүүлэлт: Номун смарт ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр сургуулийн талаар 10 минутын видео танилцуулга хийх, 15,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, төлбөрийг бүрэн шилжүүлж, урьдчилгаа дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт

олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар албан даалгаврын 1.4 "Тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах: 1.4.4. Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, төсвийг хэмнэлттэй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 33,911.6 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 "Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1 "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сургуульд 2021 онд хөрөнгө оруулалтаар "Интер сайнс" ХХК-иас нийлүүлэгдэн анх ирэхдээ үйлдлийн систем гэмтэлтэйн улмаас ашиглах боломжгүй 3 нэр төрлийн симулятор гэх сургалтын зориулалттай төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэлд 205,537.0 мянган төгрөгөөр тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй байгаа хөрөнгөнд элэгдэл тооцож, байгууллагын үр дүнг буруу илэрхийлж байгаа зөрчлийг арилгах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хэрэгцээт газарт нь шилжүүлэх хүсэлт холбогдох газарт уламжлах

2. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилгын политехникийн коллеж нь өөрийн эзэмшлийн 1680901763 дугаартай нэгж талбайдаа "Макс групп" ХХК-ийн ХТП-2837 дэд өртөөг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бариулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилгын политехникийн коллежийн герман хэл суралцагчдын "Зул сар"-ын баярыг тэмдэглэхэд зориулан 12 дугаар сарын 19-ний өдөр 422.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаартай албан тушаалын 1.3 "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах

4. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа 2017 онд худалдан авсан 2,064.8 мянган төгрөгийн цахилгааны утас бараа материалын дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хэрэгцээнд шаардлагатай хөрөнгө бэлтгэж байх, шаардлагагүй хөрөнгө нөөцөлж бэлтгэхгүй байх.

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 930,527.5 мянган төгрөгийн 5150 ширхэг хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгүүдийг ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох эсэхийг холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант онд 1,814.4 мянган төгрөгийн шатахууны зардлыг түлш халаалтын зардлаар ангилал зөрүүлэн тайлагнасан байна.	1	1,814.4			1	1,814.4	1	1,814.4				
2	Тайлант онд 32,166.2 мянган төгрөгийн барилгын засварын материалыг хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал дансанд ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.	1	32,166.2			1	32,166.2	1	32,166.2				
	Дүн	2	33,980.6	-	-	2	33,980.6	2	33,980.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Үүнээс										Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлэх асуудал	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант онд багшийн бичиг хэргийн материалын төлбөр, сургуулийн хэвлэмэл танилцуулгын төлбөр гэсэн утгатай нийт 7,950.0 мянган төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шилжүүлсэн боловч бодитоор бэлэг дурсгалын зориулалттай 2 нэр төрлийн 109 номыг худалдан авч, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.	1	7,950.0	1	7,950.0								
2	Тус коллежид 2026 оны 01 дүгээр сард зохион байгуулагдах, 3 мэргэжлийн зөвлөлийн уулзалтын өглөөний цайны зардалд 470.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.	1	470.0			1	470.0						
3	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад 4,531.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	4,531.0			1	4,531.0						
4	Номун смарт ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр сургуулийн талаар 10 минутын видео танилцуулга хийх, 15,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, төлбөрийг бүрэн шилжүүлж, урьдчилгаа дансанд бүртгэсэн байна	1	15,000.0			1	15,000.0						
5	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх	1	33,911.6			1	33,911.6						

Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	шалтгаанаар 33,911.6 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд худалдан авсан байна.											
6	Тус сургуульд 2021 онд хөрөнгө оруулалтаар "Интер сайнс" ХХК-иас нийлүүлэгдэн анх ирэхдээ үйлдлийн систем гэмтэлтэйн улмаас ашиглах боломжгүй 3 нэр төрлийн симулятор гэх сургалтын зориулалттай төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэлд 205,537.0 мянган төгрөгөөр тусгасан байна.	1	205,537.0					1	205,537.0			
7	Барилгын политехникийн коллеж нь өөрийн эзэмшлийн 1680901763 дугаартай нэгж талбайдаа "Макс групп" ХХК-ийн ХТП-2837 дэд өртөөг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бариулсан байна.	1	-					1	-			
8	Барилгын политехникийн коллежийн герман хэл суралцагчдын "Зул сар"-ын баярыг тэмдэглэхэд зориулан 12 дугаар сарын 19-ний өдөр 422.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	422.7					1	422.7			
9	Байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа 2017 онд худалдан авсан 2,064.8 мянган төгрөгийн цахилгааны утас бараа материалын дансанд бүртгэлтэй байна.	1	2,064.8					1	2,064.8			
10	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 930,527.5 мянган төгрөгийн 5150 ширхэг ширхэг хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-			
Дүн		10	269,887.1	1	7,950.0	4	53,912.6	5	208,024.5	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Барилгын политехник коллеж нь тайлант онд шилэн дансны цахим системд байршуулбал зохих мэдээллээс 19,374,032.9 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.	1	19,374,032.9	1	19,374,032.9		
	Дүн	1	19,374,032.9	1	19,374,032.9	-	-
	Нийт дүн	1	19,374,032.9	1	19,374,032.9	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 60/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд багшийн бичиг хэргийн материалын төлбөр, сургуулийн хэвлэмэл танилцуулгын төлбөр гэсэн утгатай нийт 7,950,000.00 /долоон сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шилжүүлсэн боловч бодитоор бэлэг дурсгалын зориулалттай 2 нэр төрлийн 109 номыг худалдан авч, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар албан даалгаврын 1.3-т "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулж, бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан 7,950,000.00 /Долоон сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Амарзаяа/, нягтлан бодогч /Н.Нарансүрэн/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akr\2026\0225 SAG-34.Docx

1526160490



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 308/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 33,911,610.00 /Гучин гурван сая есөн зуун арван нэгэн мянга зургаан зуун арван/ төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-т "Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Амарзаяа/, нягтлан бодогч /Н.Нарансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-45.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 310/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Номун смарт ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр сургуулийн талаар 10 минутын видео танилцуулга хийх, 15,000,000.00 /Арван таван сая/ төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, төлбөрийг бүрэн шилжүүлж, урьдчилгаа дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар албан даалгаврын 1.4-т "Тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах: 1.4.4. Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг хэмнэлттэй зарцуулж, байгууллагын төсвөөр видео танилцуулга хийлгэж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Амарзаяа/, нягтлан бодогч /Н.Нарансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 309/АД150458

Улаанбаатар хот

САГ - 2026/27/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад 4,531,000.00 /Дөрвөн сая таван зуун гучин нэгэн мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.6. Үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8. Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Амарзаяа/, нягтлан бодогч /Н.Нарансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 311/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус коллежид 2026 оны 01 дүгээр сард зохион байгуулагдах, 3 мэргэжлийн зөвлөлийн уулзалтын өглөөний цайны зардалд 470,000.00 /Дөрвөн зуун далан мянган/ төгрөгийг урьдчилан шилжүүлж, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар албан даалгаврын 1.4.1-т "Хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод гадаад албан томилолт, тээвэр шатахуун, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Амарзаяа/, нягтлан бодогч /Н.Нарансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 307/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА - ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим системд байршуулбал зохих мэдээллээс 19,374,032,900.00 /Арван есөн тэрбум гурван зуун далан дөрвөн сая гучин хоёр мянга есөн зуун/ төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах..”, гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитын шийдвэр болон албан үүргээ хангалтгүй биелүүлсэн Барилгын политехник коллежийн нягтлан бодогч /Н.Нарансүрэн/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Амарзаяа/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ

